

БАТЛАВ.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА, БРИГАДЫН  
ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН

БАРАА, МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

“МОНГОЛ ЭМ ИМПЕКС КОНЦЕРН”  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.БОЛОРМАА

2020 оны 06 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/143 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар (цаашид “захиалагч” гэх)-ыг төлөөлж Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын дарга, дэд хурандаа Ч.Цогбаяр, нөгөө талаас “Монгол эм импекс концерн” ХХК (цаашид “Нийлүүлэгч” гэх)-ийг төлөөлж дэд захирал Ш.Хонгорзул нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 06 дугаар сарын ... -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

2. Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу улсын нөөцөд бараа, материалыг бүрдүүлэх /цаашид “бараа, материал” гэх/-тэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

3. Энэхүү гэрээгээр ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис /жавелин №300/ үнэ, чанар стандарт, нийлүүлэх хугацаа, байршлыг эцэслэн тохирох үндэслэл болно.

4. Нийлүүлэх барааны үнэ:

| № | Барааны нэр  | Гарал үүсэл | Хэмжих нэгж | Тоо, ширхэг | Нэгж үнэ | Мөнгөн дүн        |
|---|--------------|-------------|-------------|-------------|----------|-------------------|
| 1 | Жавелин №300 | Франц       | банк        | 147         | 102,300  | 15,038,100        |
|   | <b>Дүн</b>   |             |             | <b>147</b>  |          | <b>15,038,100</b> |

5. Захиалагч нь бараа нийлүүлэлтийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.

6. Нийлүүлэгч хавсралтад заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис /жавелин №300/ 147 банкиг 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн дотор Улаанбаатар хот дахь Улсын нөөцийн салбарт хүргэж хүлээлгэн өгнө.

7. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үүнд:

- Гэрээний ерөнхий нөхцөл /1 дүгээр хавсралт/
- Гэрээний тусгай нөхцөл /2 дугаар хавсралт/
- Техникийн тодорхойлолт /3 дугаар хавсралт/
- Бараа, материал нийлүүлэлтийн болон санхүүжилтийн хуваарь /4 дүгээр хавсралт/

8. Гэрээ нь энд дурьдсан бараа, материал нийлүүлэх талаархи талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

9. Захиалагч, нийлүүлэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

10. Нийлүүлэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан бараа, материалыг нийлүүлж, зөрчил, доголдлыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

11. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа, материал болон зөрчил, доголдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээнэ.

12. Захиалагчийг төлөөлөн үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон гэрээ хэрэгжүүлэгч бүр бараа худалдан авах ажиллагаанд оролцох, захиалагчийн гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх, сонирхлын зөрчилгүй байна. Зөрчил үүссэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авна.

13. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН  
ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Ч.ЦОГБАЯР

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“МОНГОЛ ЭМ ИМПЕКС КОНЦЕРН”  
ХХК-ийн дэд захирал

Ш.ХОНГОРЗУЛ



Улаанбаатар хот, СБДүүрэг,  
Партизаны гудамж-6  
Утас/ факс: 51-263399  
Төрийн сан 100900031005  
Регистрийн дугаар: 9129146

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
2-р хороо Нарны зам, Өөрийн байр  
Утас/факс: 70001923, 99118537  
Хаан банк: 5003009561  
Регистрийн дугаар: 2116847

## ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 06 дугаар сарын 19

Улаанбаатар хот

Онцгой байдлын ерөнхий газар, “Монгол эм импекс концерн” ХХК-ийн хооронд 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан ..... -р гэрээний хэрэгжилтийг хоёр тал хамтран дүгнэв.

2020 оны 06 дугаар сарын 19-ны өдөр гэрээнд заасан 147 банк ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисыг Улаанбаатар хот дахь Улсын нөөцийн “Объект- 03” салбарын агуулахад хүлээлгэн өгсөн тухай.


| № | Барааны нэр                                        | Х/н  | Гэрээний дагуу нийлүүлэх тоо | Гүйцэтгэлээр:  |          |                      | Олгох /төгрөг /                                                                |
|---|----------------------------------------------------|------|------------------------------|----------------|----------|----------------------|--------------------------------------------------------------------------------|
|   |                                                    |      |                              | Нийлүүлсэн тоо | Нэгж үнэ | Бүгд үнэ /төгрөгөөр/ |                                                                                |
| 1 | Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис /жавелин №300/ | банк | 147                          | 2.000          | 102.300  | 15.038.100           | <b>15.038.100</b><br>/арван таван сая гучин<br>найман мянга<br>нэг зуу/ төгрөг |
|   | <b>Дүн</b>                                         |      | <b>147</b>                   | <b>2.000</b>   |          | <b>15.038.100</b>    |                                                                                |

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/143 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор 147 банк ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисыг гэрээнд заагдсан хугацаанд техникийн тодорхойлолтын шаардлага болон гэрээний бусад нөхцлийг бүрэн хангаж хүлээлгэн өгсөн тул гэрээний биелэлтийг хангалттай гэж 2 тал үзлээ.


### ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

#### ОБЕГ-ыг төлөөлж:


Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын дарга, дэд хурандаа

 Ч.Догбаяр

УНХТГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн хэлтсийн дарга, хурандаа

 С.Лхагвасүрэн

УНХТГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

 М.Хаш-Эрдэнэ

#### “МОНГОЛ ЭМ ИМПЕКС КОНЦЕРН” ХХК-ийг төлөөлж:

Менежер

 Ч.Бауыржан